



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/231

Мөрөн сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 28.1.2, 33 дугаар зүйлийн 33.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1, Засгийн газрын 2016 оны 10, 2020 оны 152 дугаар тогтоол, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит IX хуралдааны 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан Мөрөн сум 13 дугаар баг Радио өргөн нэвтрүүлэх станцын зүүн урд талд байршилтай газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний дуудлага худалдаанд ялсан “Нэхий таннери” ХХК /4280288/-д үйлдвэрлэлийн барилга байгууламжийн газрын зориулалттай 10080м² газрыг 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч хуулийн этгээд “Нэхий таннери” ХХК /4280288/-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН